



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 07 сарын 22 өдөр


Дугаар 386

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”, шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын санаатыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэдбазар овогтой Отгонбатыг Үйлдвэр худалдааны яамны захиалгаар АНУ-ын Харвардын Их сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр, Ням-Осор овогтой Алтантуяаг Сангийн яамны захиалгаар АНУ-ын Чикаго хотын Деврийн Их сургуулийн Келлерийн нэрэмжит менежментийн сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус хоёр жилийн хугацаатайгаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.
2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Болормаа

Н.БОЛОРМАА

00 110